



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 62

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,000,000 /таван сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй МТЗ-50 маркийн тракторыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Зулбаатар)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1 Актлах хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
62 дугаар тогтоолын хавсралт

Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын актлах хөрөнгийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Данснаас хасах болсон шалтгаан
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Трактор	MT3-50			1990	2013	214322	435116		5,000,000	5,000,000	Ашиглах боломжгүй болсон
<b>Хөрөнгийн нийт дүн</b>										<b>5,000,000</b> <i>/таван сая/</i>	<b>5,000,000</b> <i>/таван сая/</i>	